



ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2017 оны 03 сарын 31 өдөр

Дугаар 6/бс

Эрдэнэт

Төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Усны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2 дахь заалт, Улсын Их Хурлын 2010 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан “Ус” үндэсний хөтөлбөр, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2012 оны 23 дугаар тогтоолыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. “Ус” дэд хөтөлбөрийг 2017-2021 онд хэрэгжүүлэх хоёрдугаар үе шатны үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралт ёсоор баталсугай.

2. Хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулж, шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг жил бүрийн улсын болон орон нутгийн төсөвт тусгаж ажиллахыг аймгийн Засаг дарга Д.Батлутад даалгасугай.



ДАРГА

П.ПҮРЭВЛХАГВА